



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/465

Улаанбаатар хот

┌ Журам шинэчлэн батлах тухай ┐

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.7 хэсгийн тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсролын цахим мэдээллийн сан бүрдүүлэх, ажиллуулах журмыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай

2. Журмын хэрэгжилтийг удирдлагаар хангаж ажиллахыг Цахим боловсрол, статистикийн хэлтэст, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Боловсролын ерөнхий газар /Т.Ням-Очир/, Боловсролын мэдээллийн технологийн төв (Л.Энхбат)-д тус тус даалгасугай.

3. Боловсролын цахим мэдээллийн сан бүрдүүлэх, ажиллуулах үйл ажиллагаанд хяналт тавьж, журмын хэрэгжилтэд 2 жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүнг танилцуулахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалыг баталсантай холбогдуулан Боловсролын сайдын 2024 оны "Журам батлах тухай" 260 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



П.НАРАНБАЯР

14251 1324



БОЛОВСРОЛЫН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ, АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмаар боловсролын мэдээллийн сан /цаашид "мэдээллийн сан" гэх/-г бүрдүүлэх, ажиллуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Мэдээллийн санг бүрдүүлэх, ажиллуулах харилцаанд мэдээллийн эзний эрх, үүргийг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 16.1, 17.1 -д тус тус заасны дагуу зохицуулна.

1.3. Мэдээллийн санг бүрдүүлэх, ажиллуулах үйл ажиллагаанд оролцох иргэн, хуулийн этгээд нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсэгт заасан үүргийг хүлээнэ.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

2.1. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /Цаашид "яам" гэх/-тай түүний харьяа байгууллага, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага, бүх түвшний боловсролын сургалтын байгууллагад ашиглагдаж буй мэдээллийн систем хөгжүүлэгч, мэдээллийн санг бүрдүүлэх, ажиллуулах чиг үүрэг бүхий албан тушаалтан холбогдох хууль тогтоомжид заасан бусад байгууллага энэхүү журмыг мөрдөнө.

ГУРАВ. МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ

3.1. Мэдээллийн сан Боловсролын ерөнхий хуулийн 43.3-т заасан мэдээллээс бүрдэнэ.

3.2. Мэдээллийн санг "Журам батлах тухай" Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 465 дугаар тогтоолоор батлагдсан "Боловсролын цахим мэдээллийн сангийн систем, техник технологи, программ хангамжийн ерөнхий шаардлага болон төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагатай мэдээлэл солилцох журам"-д заасан мэдээллийн систем, дэд систем болон систем хөгжүүлэгчийн хөгжүүлсэн боловсролын сургалтын байгууллагад ашиглагдаж байгаа мэдээллийн систем, программ хангамжаар дамжуулан бүрдүүлнэ.

3.3. Боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төв нь байгууллагын удирдлагын болон боловсролын сургалтын зориулалтаар мэдээллийн систем, программ хангамж ашиглаж байгаа тохиолдолд “Журам батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 432 дугаар тогтоолоор батлагдсан “Боловсролын цахим мэдээллийн сангийн бүртгэл, мэдээлэл солилцох, хадгалах, хамгаалах, баяжуулах, ашиглах журам”-д заасан мэдээлэл солилцооны системээр дамжуулан мэдээлэл солилцоно.

3.4. Систем хөгжүүлэгч нь яамтай мэдээлэл солилцох гэрээ байгуулах хүсэлт ирүүлэхдээ доор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ:

- 3.4.1. албан хүсэлт, өөрийн бүтээгдэхүүний танилцуулгын хамт;
- 3.4.2. улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- 3.4.3. сервис үйлчилгээний нэр /өгөх, авах/;
- 3.4.4. холбоо барих мэдээлэл /утасны дугаар, и-мэйл хаяг/.

3.5. Яам нь энэхүү журмын 3.4-д заасан хүсэлтийг хүлээн авч энэхүү журмын 3.3-т заасан журмын дагуу систем хөгжүүлэгчтэй мэдээлэл солилцох гэрээ байгуулна.

3.6. Систем хөгжүүлэгчийн хөгжүүлсэн систем нь боловсрол сургалтын байгууллагад боловсрол, сургалтын зориулалтаар ашиглах мэдээллийн системд тавих ерөнхий болон тусгай шаардлагын шалгуур үзүүлэлтийн дагуу болон боловсролын салбарт мөрдөж буй хууль, тогтоомжийн хүрээнд ажилладаг байна.

3.7. Боловсролын мэдээллийн технологийн төв нь энэхүү журмын 3.6-д заасан шаардлагыг хангасан болон энэхүү журмын 3.4.3-т заасан сервис үйлчилгээг ажиллуулах тохиолдолд систем хөгжүүлэгчид зөвхөн нэг токен олгож, мэдээлэл солилцоно.

3.8. Энэхүү журмын 3.7-д заасны дагуу токен олгосон байгууллагын мэдээллийг Боловсролын мэдээлэл технологийн төв өөрийн байгууллагын цахим хуудсанд нээлттэй байршуулна.

3.9. Яамтай энэхүү журмын 3.5-д заасан гэрээг байгуулсан систем хөгжүүлэгч нь Монгол Улсын Кибер аюулгүй байдлын тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Монгол Улсын Өрсөлдөөний тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжийг мөрдөнө.

3.10. Боловсролын ерөнхий хуулийн 34.1, 34.2-т заасан Удирдах зөвлөл, Сургууль, цэцэрлэгийн зөвлөл нь систем хөгжүүлэгчийн хөгжүүлсэн системийг тухайн сургалтын байгууллагад ашиглах эсэхийг шийдвэрлэж, систем хөгжүүлэгчтэй гэрээ байгуулах, хяналт тавих, гэрээг цуцлах асуудлыг шийдвэрлэнэ.

3.11. Боловсролын сургалтын байгууллага үйл ажиллагааны чиглэл давхцуулахгүй хэд хэдэн систем хөгжүүлэгчтэй энэхүү журмын 3.10-д заасны дагуу систем ашиглах гэрээ байгуулж болох бөгөөд боловсролын сургалтын байгууллага

нь систем хөгжүүлэгчийн хөгжүүлсэн системд өөрийн онцлогт тохируулан ерөнхий болон тусгай шаардлагад тусгагдаагүй нэмэлт модуль хөгжүүлж, нэвтрүүлэх саналаа гэрээнд нэмэлтээр тусгаж болно.

3.12.Боловсролын сургалтын байгууллага энэхүү журмын 3.10-д заасан гэрээг тухайн боловсролын сургалтын байгууллагын Удирдах зөвлөл болон Сургууль, цэцэрлэгийн зөвлөлийн шийдвэрийн хамт Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага /Цаашид “БЕГ” гэх/-т цахимаар хүргүүлж, бүртгүүлнэ.

3.13.БЕГ нь энэхүү журмын 3.12-т заасан гэрээг бүртгэж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавина.

3.14.Энэхүү журмын 3.13-т заасан бүртгэлд гэрээний хугацаа, гэрээний өөрчлөлт, бусад холбогдох мэдээллийг тусгаж өөрийн байгууллагын цахим хуудсанд нээлттэй байршуулна.

3.15.Боловсролын сургалтын байгууллага, систем хөгжүүлэгч хооронд байгуулсан гэрээ цуцлагдсан тохиолдолд тооцоо нийлсэн акт, гэрээ цуцалсан баримтыг үндэслэн Боловсролын мэдээллийн технологийн төв холбогдох токеныг цуцалж, шинээр гэрээ байгуулсан систем хөгжүүлэгчид энэхүү журмын 3.7-д заасны дагуу токен олгоно.

3.16.Боловсролын сургалтын байгууллага энэхүү журмын 3.10-д заасан гэрээг байгуулахдаа ашиглалтын зардлыг доор дурдсан эх үүсвэрээс санхүүжүүлнэ. Үүнд:

3.16.1.боловсролын сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын цахим хэрэглээний зардал;

3.16.2.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс өгөх хөрөнгө;

3.16.3.хуульд заасан бусад.

3.17.Систем хөгжүүлэгч нь энэхүү журмын 3.5-д заасан гэрээний дагуу боловсролын сургалтын байгууллагын анхан шатны бүртгэлийн мэдээллийг бодит цагийн горимоор энэхүү журмын 3.3-т заасан мэдээлэл солилцооны системд хүргүүлнэ.

3.18.Яам нь энэхүү журмын 3.2-т заасан журмын дагуу сервис хөгжүүлэлтийн төлөвлөлтийг тухайн сервисийг ашиглахаас 3 сарын өмнө батлах бөгөөд Боловсролын мэдээллийн технологийн төв тухайн сервисийг ашиглахаас 1 сарын өмнө туршилтын хувилбарыг гаргана.

3.19.Боловсролын сургалтын байгууллага нь систем хөгжүүлэгчийн хөгжүүлсэн мэдээллийн системийг ашиглана.

3.20.Боловсролын сургалтын байгууллагын ашиглаж буй систем нь Монгол Улсад хэрэглэгдэж байгаа бүх төрлийн төлбөр, тооцооны системийг дэмждэг байна.

ДӨРӨВ. МЭДЭЭЛЛИЙН САНД ХАНДАХ ЭРХИЙН ЗОХИЦУУЛАЛТ

4.1. Энэхүү журмын 3.2.-т заасан мэдээллийн системд нэвтрэх эрх дараах төрөлтэй байна. Үүнд:

- 4.1.1. Харах (read only);
- 4.1.2. Гүйцэтгэх (read+write);
- 4.1.3. Удирдах (Create / Drop / Grant).

4.2. Энэхүү журмын 4.1.2, 4.1.3-т заасан эрхийг яамны зөвшөөрснөөр Боловсролын мэдээллийн технологийн төв олгож, цуцална.

4.3. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан мэдээллийг зөвхөн энэхүү журмын 4.1.2, 4.1.3.-т заасан эрх эзэмшигч албаны чиг үүргийн хүрээнд ашиглана.

4.4. Энэхүү журмын 4.1-т заасан эрх эзэмшигч нууц задруулахгүй байх баталгааг яамны нууц хамгаалах ажилтанд бичгээр гаргана.

4.5. Харах эрхийг яам, БЕГ, яамны харьяа байгууллага болон боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын төрийн жинхэнэ албан хаагч эзэмших бөгөөд дараах үйлдлийг гүйцэтгэнэ. Үүнд:

4.5.1. Хүний хувийн мэдээллийн хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, шийдвэрээр нууцлагдаагүй мэдээллийг харах;

4.5.2. Боловсролын салбарын албан ёсны болон захиргааны статистикийн тайлан мэдээлэл, ухаалаг тайлангийн хянах самбар /дашборд/-ын мэдээллийг харах, ашиглах.

4.6. Гүйцэтгэх эрхийг БЕГ, яамны харьяа байгууллага, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын холбогдох нэгжийн мэдээллийн сангийн өгөгдлийг бүрдүүлэх, ашиглахтай холбоотой чиг үүрэг бүхий төрийн жинхэнэ албан хаагч эзэмших бөгөөд дараах үйлдлийг гүйцэтгэнэ. Үүнд:

4.6.1. Орон нутгийн байгууллагын холбогдох нэгжийн мэдээллийн сангийн мэдээллийг өөрийн эрхлэх асуудлын хүрээнд харах, бүртгэх, залруулах, хайх, баталгаажуулах, түдгэлзүүлэх, цуцлах, хянах, сэргээх, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, боловсруулах, тайлагнах;

4.6.2. БЕГ, яамны харьяа байгууллага нь өөрийн үндсэн чиг үүрэгт хамаарах улсын түвшний мэдээллийг харах, бүртгэх, залруулах, хайх, баталгаажуулах, түдгэлзүүлэх, цуцлах, хянах, сэргээх, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, боловсруулах, тайлагнах;

4.7. Удирдах эрхийг яамны энэхүү журмын 3.1-т заасан сангийн зохицуулалт хариуцсан нэгжийн салбарын өгөгдлийн санг хянах, нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий төрийн жинхэнэ албан хаагч эзэмших бөгөөд энэхүү журмын 4.1.1, 4.1.2-д заасан эрхийг нэгдсэн удирдлагаар хангаж, дараах үйлдлийг гүйцэтгэнэ. Үүнд:

4.7.1. Харьяа байгууллагын болон улсын хэмжээнд бүх түвшний мэдээллийг харах, залруулах, хайх, баталгаажуулах, түдгэлзүүлэх, цуцлах, хянах, сэргээх, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, боловсруулах, тайлагнах;

4.7.2. Бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын монгол, гадаад суралцагчийн элсэлт, төгсөлтийн болон шилжилт хөдөлгөөний үйл ажиллагаанд хяналт тавьж, бүртгэх, баталгаажуулах, цуцлах, залруулга, засвар хийх;

4.8. Цахим мэдээллийн сангийн өгөгдөлд дүн шинжилгээ хийж, ухаалаг тайлан /дашборд/-ийн хянах самбар боловсруулахдаа олон улс, үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн батлагдсан арга, аргачлалыг дагаж мөрдөнө.

4.9. Энэхүү журмын 4.1.1-4.1.3-т заасан эрх эзэмших төрийн жинхэнэ албан хаагч нь Төрийн болон албаны нууцыг хамгаалах тухай хуулийн дагуу мэдээллийн санд агуулагдах мэдээллийг задруулахгүй байх үүрэгтэй бөгөөд нэвтрэх нэр, нууц үг нь Яамны албаны нууцад хамаарах тул бусдад дамжуулахыг хориглоно.

4.10. Энэхүү журмын 4.1.1-4.1.3-т заасан эрх эзэмшигчийн чиг үүрэг өөрчлөгдсөн болон ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд системд хандах эрхийг цуцална.

4.11. Энэхүү журмын 4.1.1.-4.1.3.-т заасан эрх эзэмшигч мэдээллийн сангийн өгөгдөлд дүн шинжилгээ хийж, боловсруулсан тайлан, мэдээлэл нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт хамаарч байгаа бол үр дүнг нийтэд тархааж болно.

ТАВ. МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ӨГӨГДЛИЙГ ЗАЛРУУЛАХ

5.1. Мэдээллийн сангийн өгөгдлийг хянаж, бүрэн бус, алдаатай мэдээлэл илэрсэн нь нотлох баримтаар батлагдсан бол залруулга, засварыг доор дурдсанаар хийнэ.

5.1.1. Мэдээлэл хариуцагч, түүний ажилтан, албан хаагч нь зөвхөн өөрийн бүртгэсэн, бүрдүүлэлт, баяжуулалт хийсэн мэдээлэлд залруулга, засвар хийх ба дээд шатны системд хандах эрхтэй албан тушаалтан нь өөрчлөлт хийхгүй;

5.1.2. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 17.1.2-т заасны дагуу мэдээллийн эзэн нь алдаатай мэдээллийг залруулах талаар мэдээлэл хариуцагчид мэдэгдэж, өөрчлөлт оруулах, мэдээлэл засах тухай үндэслэл, нотлох баримтын хамт яам, БЕГ, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагад хүсэлт гаргах;

5.1.3. Залруулга, засвар хийх тухай мэдэгдлийг нотлох баримтын хамт ажлын 3 өдрийн дотор мэдээлэл хариуцагчид хүргүүлэх;

5.1.4. Мэдэгдэл хүлээн авсан мэдээлэл хариуцагч нь ажлын 3 өдөрт багтаж залруулга, засварыг хийж, энэхүү журмын 5.1.2-т заасан хүсэлт гаргасан мэдээллийн эзэнд эргэн мэдээлэх.

5.1.5. Мэдээлэл хариуцагч татан буугдсан болон өөрчлөн байгуулагдсан тохиолдолд БЕГ, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын холбогдох чиг үүрэг бүхий албан тушаалтан залруулгыг хууль, журамд нийцүүлэн хийж, залруулга хийсэн тухай түүх, нотлох баримтыг архивлан хадгалах.

5.2. БЕГ, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь мэдээлэл хариуцагчаас ирүүлсэн албан ёсны хүсэлтэд үндэслэн залруулгыг хийж, залруулга хийсэн тухай түүх, нотлох баримтыг архивлан хадгална.

ЗУРГАА. НӨХӨН БҮРДҮҮЛЭЛТ

6.1. Бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын боловсролын баримт бичгийн нөхөн бүрдүүлэлт, мэргэжлийн дүйцүүлэлтийг Архивын ерөнхий газар, яам, боловсролын сургалтын байгууллагын архивын мэдээлэл, статистикийн мэдээлэл, холбогдох журам, Боловсролын чанарын баталгаажуулалт-магадлан итгэмжлэлийн байгууллагын лавлагаанд тус тус үндэслэн мэдээллийн санд БЕГ бүртгэж, баталгаажуулна.

6.2. Дээд боловсролын сургалтын байгууллага нь энэхүү журмын 6.1-т заасан баримт бичигт үндэслэн боловсролын баримт бичгийг мэдээллийн системд бүртгэж БЕГ баталгаажуулна. Мэдээллийн үнэн, бодит байдлыг тухайн дээд боловсролын сургалтын байгууллага хариуцна.

6.3. Яамны шийдвэрээр татан буугдсан дээд боловсролын сургалтын байгууллагыг 2005 он болон түүнээс өмнөх онд төгссөн төгсөгчийн боловсролын баримт бичгийг энэхүү журмын 6.1-т заасны дагуу бүртгэх боломжгүй тохиолдолд иргэний хүсэлт, нотариатаар гэрчлүүлсэн дипломын хуулбар, түүний эх хувийг үндэслэн бүртгэн баталгаажуулж болно. Нотариатаар гэрчлүүлсэн баримт бичгийн мэдээллийн үнэн, бодит байдлыг тухайн иргэн өөрөө хариуцна.

6.4. Энэхүү журмын 6.1-6.3-т заасны дагуу төгсөгчийг бүртгэх нотлох баримт бүрдэхгүй тохиолдолд шүүхийн шийдвэрийг үндэслэн бүртгэнэ.

6.5. Олгосон боловсролын баримт бичгийн дугаар давхардсаныг энэхүү журмын 6.1, 6.2, 6.3-д заасан мэдээллээр баталгаажсан тохиолдолд сүүлд бүртгэгдсэн боловсролын баримт бичгийн дугаарын ард “ * ” тэмдэглэл хийж, тодорхой тайлбар бичиж бүртгэж, баталгаажуулна.

6.6. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага, боловсролын сургалтын байгууллага холбогдох журмын дагуу боловсролын баримт бичгийг иргэнд нөхөн олгосон тохиолдолд шинээр олгосон баримт бичгийн дугаарыг тухай бүр энэхүү журмын 3.2-т заасан мэдээллийн системд бүртгэж, нөхөн олгосон шалтгааныг бичнэ.

6.7. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага, боловсролын сургалтын байгууллага холбогдох журмын дагуу боловсролын баримт бичгийг иргэнд нөхөн олгосон тохиолдолд шинээр олгосон баримт бичгийн дугаарыг тухай бүр энэхүү журмын 3.2-д заасан мэдээллийн системд бүртгэж, нөхөн олгосон шалтгааныг бичнэ.

6.8. Баримт бичгийн нөхөн бүрдүүлэлттэй холбогдох үйл ажиллагаанд яам хяналт тавина.

ДОЛОО. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН СТАТИСТИК МЭДЭЭ, ТАЙЛАНГИЙН БОЛОВСРУУЛАЛТ

7.1. Мэдээллийн систем нь боловсролын салбарын захиргааны болон албан ёсны статистик мэдээ, мэдээллийг бодит цаг хугацаанд, алдаагүйгээр нэгтгэн боловсруулж, батлагдсан хугацаанд батлагдсан маягтын дагуу тайланг гаргах, боловсруулалтын үр дүнг дүрслэн харуулах ухаалаг тайлангийн системтэй байна.

7.2. Боловсролын салбарын захиргааны болон албан ёсны статистик мэдээ, мэдээллийн тайланг батлагдсан хугацаанд батлагдсан маягтын дагуу цахим системээр гаргаагүй бол Статистикийн тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн дагуу буруутай этгээдэд хариуцлага тооцох ба яамны удирдлагуудад албан ёсоор танилцуулж, тусгай зөвшөөрөл цуцлах, яамтай байгуулсан гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.

7.3. Суралцагчийн өдөр тутмын ирц, шилжилт хөдөлгөөнийг мэдээллийн системд өдөр тутам бүртгэх ба үр дүнг хянах хяналтын самбартай байна.

НАЙМ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

8.1. Мэдээллийн сангийн анхдагч өгөгдөл-мэдээллийн зөрүүтэй, алдаатай, хамралт дутуу бүрдүүлэлтээс үүсэх аливаа асуудлыг тухайн бүртгэсэн, нэгтгэсэн, хянасан мэдээлэл хариуцагч байгууллагын буруутай ажилтан, албан тушаалтан, систем хөгжүүлэгч хариуцаж, холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

8.2. Яамтай энэхүү журмын 3.5-т заасан гэрээ байгуулсан систем хөгжүүлэгч нь гэрээний үүргээ биелүүлээгүй, хангалтгүй биелүүлсэн эсвэл хууль журам зөрчсөн болон эрх бүхий этгээдийн шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд мэдээлэл солилцох гэрээг цуцалж, холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

8.3. Энэхүү журмын 3.6-д заасан шаардлагыг 2 буюу түүнээс дээш удаа хангаагүй тохиолдолд мэдээлэл солилцох гэрээг хугацаанаас өмнө цуцлах үндэслэл болно.

8.4. Энэхүү журмын 3.5-т заасан гэрээ цуцлагдсанаас үүссэн хохирлыг систем хөгжүүлэгч байгууллага бүрэн хариуцах ба мэдээллийн сангийн өгөгдөлтэй холбоотой үүссэн зөрчлийг Статистикийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон бусад холбогдох хуулийн дагуу шийдвэрлэнэ.

8.5. Энэхүү журмын 8.1-8.3-д заасан нөхцөл байдал үүссэн даруй БЕГ нь түүнтэй холбогдох нотлох баримтыг яаманд хүргүүлнэ.

8.6. Энэхүү журмын 3.2-т заасан мэдээллийн систем болон энэхүү журмын 3.3-т заасан мэдээлэл солилцооны систем, энэхүү журмын 3.18-д заасан сервис хөгжүүлэлтээс шалтгаалж мэдээллийн санг мэдээллийн алдагдалд оруулсан бол Боловсролын мэдээллийн технологийн төвд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

8.7. Боловсролын сургалтын байгууллагын удирдлага нь Боловсролын ерөнхий хуулийн 34.1, 34.2-т заасан Удирдах зөвлөл, Сургууль, цэцэрлэгийн зөвлөлийн шийдвэргүйгээр систем хөгжүүлэгчтэй бие даан гэрээ байгуулах, байгуулагдсан гэрээг үндэслэлгүй цуцлах, гэрээний үүргийг мөрдөөгүйгээс

шалтгаалж мэдээллийн санг мэдээллийн алдагдалд оруулсан, систем хөгжүүлэгч талыг төлбөрийн алдагдалд оруулсан бол түүнээс үүдэн гарах хохирлыг удирдлага өөрөө хариуцах ба холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

8.8. Боловсролын салбарын мэдээлэлд дүн шинжилгээ, боловсруулалт хийхэд ашиглагдсан анхдагч өгөгдөл, мэдээллийн бүрэн хамрагдалт, чанар, үнэн бодит байдлыг БЕГ болон яамны харьяа байгууллага хариуцаж, орон нутгийн боловсролын байгууллага болон боловсролын сургалтын байгууллагын мэдээллийн сан бүрдүүлэлтэд өдөр тутмын хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангах ба өгөгдлийн чанар, үнэн бодит байдалд холбогдох хууль журмын дагуу хариуцлага хүлээнэ.

---o0o---